



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

**ЭРХ ЧӨЛӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
НАМЫН ДАРГА
Ш.ТӨМӨРСҮХ ТАНАА**

2021.08.06 № 1804

танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэгт тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 18, 28 дугаар тойргуудад явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцох “Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020” Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” болон холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

“Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-д тус тус нийцсэн бөгөөд Монгол Улсын Их хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцохоор Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороонд бүртгүүлсэн тус намын мөрийн хөтөлбөрт өөрчлөлт ороогүй байна.

“Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам”-ын мөрийн хөтөлбөр /.....¹⁰ хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хороонд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ЗАНДАНБАТ

000011

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
“ЭРХ ЧӨЛӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ НАМ”-ЫН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

*Уриа: Авилгачдыг цээрлүүлж,
шударга ёсыг тогтооно.*

Оршил

Монгол Улсад эдийн засгийн хямрал, улс төр засаглалын тогтворгүй байдал үргэлжилж, түүний улмаас нийгэмд ажилгүйдэл, ядуурал нэмэгдэж, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж, иргэд, төрийн албан хаагчдын амьжиргаа эрс хүндэрч байгаа нь нэгдмэл бодлоготой эх оронч үзэл баримтлалтай, хариуцлагатай төр байхгүй байгаагийн илэрхийлэл юм.

Ийм хүнд нөхцөлд төрийн эрх барих дээд байгууллага УИХ-ын ээлжит сонгуульд улс төрийн нам, эвсэл, бие даагчид мөрийн хөтөлбөрөө боловсруулж Монгол улсын Үндсэн хуулийн тогтолцоог төгөлдөржүүлэх, Үндэсний баялагаа зөв ашиглах, Улс орноо хөгжүүлэх, Ард иргэдээ эрх чөлөөт амьдралын баталгаагаар найдвартай хангах түүхэн сонголтын цаг үетэй тулгараад байгаа билээ.

Энэ цаг дор ЭЧХН нь Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуульд “Нэгдмэл бодлоготой, эх оронч, хариуцлагатай шинэ төрийг төлөвшүүлэх” тухай хэлэлцүүлэг өрнүүлж, олон түмний санаа бодлыг тодорхой асуудлуудаар, тандан судлах замаар мөрийн хөтөлбөрөө боловсруулан сонгогч та бүхэндээ хүргэж байна.

Намын зорилго, баримтлах зарчим

1. Хүний хөгжлийн индексийг 2024 онд өмнөх 4 жилийн өсөлтөөс доошгүй байлгах уур амьсгал бүрдүүлнэ.
2. Төр засаг, бизнесд дэмжлэг үзүүлэх супер компьютерт суурилсан туслах тархи бүтээж, менежмент төлөвлөгөө хуулийн заалтууд, хөтөлбөрүүдийг оновчтой болгоно.
3. Ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн.
4. Банкны барьцааны эрх зүйн орчинг шинэчилэн хуульчилж олон улсад мөрддөг зээлийн эрх зүйн орчинг санаачилж дэс дараалагатай арга хэмжээг авна.
5. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих хөгжлийн санхүүжилтийн болон санхүүгийн зах зээлийн зохистой тогтолцоог иргэдэд тогтвортой хөгжүүлэх зорилгоор орон сууцны зээлийн хүүг 3 хүртэл хувиар бууруулах урьдчилгаа хувь



00000004

00000005

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
“ЭРХ ЧӨЛӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ НАМ”-ЫН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

*Уриа: Авилгачдыг цээрлүүлж,
шудрага ёсыг тогтооно.*

Оршил


Монгол Улсад эдийн засгийн хямрал, улс төр засаглалын тогтворгүй байдал үргэлжилж, түүний улмаас нийгэмд ажилгүйдэл, ядуурал нэмэгдэж, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж, иргэд, төрийн албан хаагчдын амьжиргаа эрс хүндэрч байгаа нь нэгдмэл бодлоготой эх оронч үзэл баримтлалтай, хариуцлагатай төр байхгүй байгаагийн илэрхийлэл юм.

Ийм хүнд нөхцөлд төрийн эрх барих дээд байгууллага УИХ-ын ээлжит сонгуульд улс төрийн нам, эвсэл, бие даагчид мөрийн хөтөлбөрөө боловсруулж Монгол улсын Үндсэн хуулийн тогтолцоог төгөлдөржүүлэх, Үндэсний баялагаа зөв ашиглах, Улс орноо хөгжүүлэх, Ард иргэдээ эрх чөлөөт амьдралын баталгаагаар найдвартай хангах түүхэн сонголтын цаг үетэй тулгараад байгаа билээ.

Энэ цаг дор ЭЧХН нь Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуульд “Нэгдмэл бодлоготой, эх оронч, хариуцлагатай шинэ төрийг төлөвшүүлэх” тухай хэлэлцүүлэг өрнүүлж, олон түмний санаа бодлыг тодорхой асуудлуудаар, тандан судлах замаар мөрийн хөтөлбөрөө боловсруулан сонгогч та бүхэндээ хүргэж байна.

Намын зорилго, баримтлах зарчим

1. Хүний хөгжлийн индексийг 2024 онд өмнөх 4 жилийн өсөлтөөс доошгүй байлгах уур амьсгал бүрдүүлнэ.
2. Төр засаг, бизнесд дэмжлэг үзүүлэх супер компьютерт суурилсан туслах тархи бүтээж, менежмент төлөвлөгөө хуулийн заалтууд, хөтөлбөрүүдийг оновчтой болгоно.
3. Ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн.
4. Банкны барьцааны эрх зүйн орчинг шинэчилэн хуульчилж олон улсад мөрддэг зээлийн эрх зүйн орчинг санаачилж дэс дараалалтай арга хэмжээг авна.
5. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих хөгжлийн санхүүжилтийн болон санхүүгийн зах зээлийн зохистой тогтолцоог иргэдэд тогтмол хөгжүүлэх зорилгоор орон сууцны зээлийн хүүг 3 хүртэл хувь болгож урьдчилгаа хувь



000012

- авахгүй, төрөөс баримталж байгаа орон сууцны зээлийн түрээсийн хэлбэрийг өөрчлөх эрх нээгдэх эрх зүйн орчинг судална
6. Үндэсний үйлдвэрлэлийг гурвалсан холбоогоор бодитоор дэмжинэ. Мөн малчдад ноогддог түүхий эдийн урамшууллыг хоршооллоор дамждаг биш шууд эзэндээ хүрдэг эрх зүйг бий болгоно. Э/З-г эрчимжүүлэх нэмэлт арга хэмжээ авч нэг хүнд ногдох ҮНО-г нэмэгдүүлэх боломж байгааг хэрэгжүүлэхийг эрмэлзнэ. Хүний Хөгжлийн Индексийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлэх арга хэмжээ авна.
 7. Төрийн өмчийн оролцоотой компаниудыг ажиллуулж Норвегийн уул уурхайн эрх зүй орчинг Монголын хөрсөнд тохирох эсэхийг судална.
 8. Авилгалтай тэмцэх, эрүүгийн хуулинд өөрчлөлт оруулж хууль бусаар олсон, оруулсан орлогыг хурааж, насаар төрийн албанд ажиллах эрхийг хасж гурван үеэрээ төрийн албанд ажиллах эрхийг хориглосон эрх зүйн орчинг бий болгож цаазын ялыг сэргээх асуудлыг судална.
 9. Байгаль орчин ногоон хөгжлийн бодлогын эрх зүйн орчинг сайжруулна.
 10. Эрүүл мэндийн салбар
 11. Төрийн дархлаа
 12. Усны бодлого
 13. Залуучууд, залуу гэр бүл, ахмад настны хүрээнд

Дээрх сэдвийн хүрээнд “Нэгдмэл бодлоготой эх оронч, хариуцлагатай шинэ төрийг төлөвшүүлэх”- хэлэлцүүлэгийг өрнүүлж улс төрийн зарим нам, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагууд, ахмад буурлууд, оюутан залуус, өрх толгойлсон эмэгтэйчүүд дэмжин хамтран ажиллахаа илэрхийлсээр байгаад бид урамтай байна.

Энэхүү хариуцлагатай үзэл бодлыг төлөвшүүлэхийн тулд нийгмийн олон давхаргын янз бүрийн хүмүүстэй уулзаж санаа бодлоо солилцож, нягтлан тунгааж ажиллахаа илэрхийлж байна.

Нэгдмэл бодлоготой эх оронч, хариуцлагатай шинэ төрийг бэхжүүлнэ.


Нам нь төрийн болон олон нийтийн ажил, улс төрийн амьдралд оролцож олсон өөрийн туршлага, мэдлэг, сургамжаа бүтээлчээр ашиглаж Нэгдмэл бодлоготой эх оронч, хариуцлагатай шинэ төрийг төлөвшүүлэх, улс орныхоо хөгжил дэвшил, ард түмнийхээ сайн сайхан амьдралын төлөө бүх боломжоо дайчлан ажиллана. Улс төржилт, талцлыг халж бүтээлч, үр ашигтай шинэчлэл өөрчлөлт, хийхийг зорино.

Улсын Их Хурал, Засгийн газар, орон нутгийн удирдлага, олон нийтийн төлөөлөл, иргэдтэйгээ хамтран тэдний эрх ашигт нийцсэн, ажлуудыг санаачилан хэрэгжүүлэнэ.

Өнөөдөр манай улсад цаг алдалгүй засч залруулан зөв болгох зүйл улам ихээр нэмэгдсээр л байна.

Нэгдмэл бодлоготой - Хариуцлагатай төр, Эрүүл ногоон байгаль, Тэнцвэртэй эрхийн төлөө тэмцэлд иргэн таны оролцоо хамгаас чухал хэрэгтэй.

Эрх мэдлийг авилга, хээл хахуулийн аргаар авсан улс төрийн тодорхой бүлэглэл, бие хүмүүсийн хуйвалдааныг таслан зогсоож, тэдэнтэй хуулийн дагуу хариуцлага тооцох,



тэднийг улс төрийн талбараас шударгаар зайлуулах бодлого, арга механизмыг баримтлан ажиллана.

Тэд урьдын адил сонгогчдын саналыг худалдан авах, үл биелэгдэх хуурамч хөтөлбөр дэвшүүлж олон түмнийг төөрөгдүүлэх зэрэг хуучин бохир аргаа дахин хэрэглэхээр зэхэж байна.

Монголчууд бид улс төр бизнесийн эдгээр бүлэглэлүүдэд дахин хууртвал үндэсний сүйрэлд хүрэх аюултай тулгарна гэдгийг ард түмэндээ онцлон анхааруулж байна.

Монгол Улсын хөгжлийн гарц

Тус намын мөрийн хөтөлбөр нь нийгмийн тогтвортой байдлыг хангахын тулд эдийн засаг, улс төр, ёс суртахуун, үзэл санаа, соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, спорт, эрүүл мэнд, гэр бүл, хил хязгаарын бүрэн бүтэн аюулгүй байдал, байгаль экологи зэрэг нэгдмэл бодлоготой эх оронч, хариуцлагатай шинэ төрийг төлөвшүүлэгч үндсэн хүчин зүйлүүдийг цогцоор нь өөрчлөн шинэчилэх стратеги төлөвлөгөө юм.

Төр болон нийгмийн бохирдолыг бид хамтын хүчээр зогсоох “нэгдмэл бодлоготой эх оронч, хариуцлагатай төрийн тогтолцоо”- бидэнд нэн шаардлагатай.


Тиймээс:

1. **Нэгдмэл эх оронч, хариуцлагатай шинэ төрийн хувьсгал** – Намчирхдаг, жалга довны үзлийг дэвэргэсэн өнөөгийн улс төр, сонгуулийн тогтолцоог халж, нэгдмэл эх оронч үзэлд бэхжүүлсэн, Монгол хүний эв эеийг хичээдэг хүлээцтэй уужуу тайван ухаан, бие биеэ хайрлан элгэмсдэг халуун сэтгэл, шударга үнэнийг дээдэлдэг ёс жудгийг улс төрийн тогтолцоонд нэвтрүүлэх.

2. **Монголын анхдагч оюунлаг иргэдийн үзэл баримтлалын хувьсгал** – Боловсрол, соёл шинжлэх ухаан, эрүүл мэнд, спортыг нийгмийн тэргүүлэх чиглэл болгон, монгол эрдэмтдийн шинэ бүтээл туурвилын үр дүнг үйлдвэрлэл, амьдралд хэрэгжүүлэх, хүн амын өсөлт, гэр бүлийг дэмжих зарчмыг баримтлах.

3. **Шинэ эдийн засгийн хувьсгал** – Ашигт малтмал, газрын баялаг тэр дундаа Тавантолгой, Оюутолгой болон бусад стратегийн ордуудыг хамгийн ашигтай хувилбараар шийдвэрлүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх. Мөн үндсэний өвөрмөц баялаг болох бэлчээрийн монгол малын ашиг шим ашиглалтыг нэмэгдүүлж, гадаад зах зээлд гаргах замаар улсын сан хөмрөгт валютын шинэ эх үүсвэрийг олох гарцыг бий болгох.

4. **Хариуцлагатай шинэ төрийг төлөвшүүлэх хувьсгал** – Улс төрийн намуудын ойлголцол, эв нэгдлийг хангаж төрийн тогтвортой байдлыг эрхэмлэн ажиллана. Аливаа улс төрийн асуудал, зөрчлийг харилцан буулт хийх, зөвшилцөх аргаар шийдвэрлэдэг нэгдмэл эх оронч үзэлтэй хариуцлагатай төрийг төлөвшүүлэх.



000012

5. Үндэсний аюулгүй байдлын хувьсгал – Хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж байгаа ундны усны хомсдол, цөлжилт, ус, хөрс, агаарын бохирдол, цөмийн болон бусад химийн аюултай хог хаягдлын хор хөнөөлийг нэн даруй арилгаж дахин шинээр үүсэн бий болохоос урьдчилан сэргийлнэ. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг Улс орны хөгжил цэцэглэлт бүтээн байгуулалтын салбарт татан оролцуулах. Зэвсэгт хүчин, хилийн цэрэг тус тусдаа, нэгдмэл зохион байгуулалтгүй байгааг өөрчилж, орчин үеийн хандлага, түүхэн уламжлалд нийцүүлэн батлан хамгаалах салбарыг бэхжүүлнэ.

1. Нэгдмэл бодлоготой эх оронч үзэл

1.1 Төрийн өндөр албан тушаалтны эрх зүйн болон улс төр, ёс зүйн хариуцлагын тогтолцоог өндөржүүлэх, тэдэнтэй хариуцлага тооцдог байх.

1.2 Авилгалын улс төрийн хүрээн дэх мөнгөний нөлөөллийг арилгах эрх зүйн орчинг бүрдүүлж, энэ талаар шийдвэртэй арга хэмжээ авна.

1.3 Төрийн албан хаагчдыг мэдлэг, туршлага, ур чадвараар нь сонгон авдаг журмыг хуульчилж хатуумердөж, төрийн өндөр албан тушаалтны зүгээс албан хаагчдын сонгоншалгаруулалт, томилгоонд хөндлөнгөөс оролцохыг зогсооно.

1.4 Гааль, татварын байгууллагуудын эрх зүйн орчинг сайжруулж, үйл ажиллагаанд нь олон нийтийн хяналт тавих аргыг нэвтрүүлнэ.

1.5 Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн гүншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

1.6 Улс төрийн нөлөөнөөс ангид, хүний эрхийг дээдэлсэн, шударга, ил тод шүүх эрх мэдлийг төлөвшүүлнэ.

1.7 Монгол хүний нэгдмэл эрх чөлөөний дайсан болсон нам дээр суурилсан төрийг татан буулгаж нэгдмэл бодлоготой эх оронч үзэлтэй хариуцлагатай шинэ төрийг төлөвшүүлэх зарчмыг барьдаг шинэ төрийг байгуулана.

1.8 Монголын улс төрийн намуудыг гишүүнчлэлгүй, өмч хөрөнгөгүй болгоно. Ингэснээр Монгол хүний эрх чөлөө баталгаажиж, нэгдмэл эх оронч үзэл төлөвшинэ.

1.9 Засгийн газрын бүтцийг бүрэн шилжүүлж хөгжлийн бодлогыг төрийн хэтийн төлөвлөлттэй уялдуулан явуулдаг тогтолцоог хэрэгжүүлнэ.

1.10 Ардчиллын гурван үнэт зүйл болох эрх чөлөө, тэгш эрх, эв нэгдэл гурвыг төрийн үйл ажиллагаанд бүрэн гүйцэд хэрэгжүүлэхийг зорилго болгоно.

1.11 Монгол үндэстэний эсрэг гэмт хэрэг үйлдэгчид төдийгүй нийт сонгогчдын сонгох эрхийг хаан боогдуулж байгаа олигархиудыг Монголын улс төрөөс цэвэрлэнэ.

1.12 Захиргааны болон албан тушаалтны дур зоргоор хүний эрх, өмч хөрөнгө, бизнес, хууль ёсны үйл ажиллагаанд саад болдог, халддаг явдлыг таслан зогсооно.




00000006

1.13 Архи тамхигүй, хоггүй, эрүүл ажиллаж амьдрах, иргэдийн зөв амьдрах хэв шинжийг бүрдүүлэхэд анхаарна.


2. Монголын анхдагч оюунлаг иргэдийн үзэл баримтлал

- 2.1 Хүн амын өсөлтийг дэмжсэн төрийн бодлого, хууль санаачилах.
- 2.2 Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийг боловсронгуй болгох төр, гэр бүл, иргэн бүрийн үүрэг хариуцлагыг сайжруулах.
- 2.3 Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт түүхийг гуйвуулах, сургалтын программийг хэн дуртайн өөрчилдөг асуудлыг зогсоох, гадаад орнуудын тэргүүний стандартыг нэвтрүүлэх нэрээр шашны урсгалыг сурталчилахыг халах
- 2.4 Ерөнхий боловсролын сургалтын тогтолцоог шинэчилэн найруулах
- 2.5 Ерөнхий боловсролын сургуулийн багш нар болон Эрүүл мэндийн салбарын эмч, сувилагч нарын мэргэжил дээшлүүлэх, хөдөлмөрийн үнэлэмжийн тогтолцоог боловсронгуй болгох.
- 2.6 Дээд боловсролын салбарт шударга өрсөлдөөний зарчмыг нэвтрүүлнэ. Төрийн өмчийн сургуулиудын удирдлага, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгож сургалтын чанарт тавих шалгуурыг өндөржүүлэх.
- 2.7 Спортын төвлөрсөн арга хэмжээ тив, дэлхийн чанартай тэмцээнийг өөрийн оронд зохион байгуулах, тамирчдын бие бялдар, дасгал сургуулалтын зөв хэв шинжийг бүрдүүлэхэд анхаарна. Тамирчдын хариуцлагыг өндөржүүлэх.
- 2.8 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, бүх нийтийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлнэ.
- 2.9 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өрх айл, иргэн бүрт чанартай, хүртээмжтэй хүргэж, иргэд эмнэлгийн байгууллага, эмчээ сонгон үйлчлүүлэх боломж олгоно.
- 2.10 **Шинэ үе - Эрүүл хүүхэд хөтөлбөрийг санаачилан хэрэгжүүлнэ.**
- 2.11 Эрүүл мэндийн салбарын үйлчилгээг боловсронгуй болгож, иргэдэд хүнд сурталгүй, цаг алдалгүй, хариуцлагатай үйлчилдэг болгох тал дээр санал санаачилга гаргаж ажиллана.
- 2.12 Ахмад настан, нярай хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох тэтгэмжийн журмыг боловсронгуй болгох, эм, хэрэгсэл, асаргаа, сувилаганы нөхцлийг сайжруулах зорилт тавина.
- 2.13 Эмч нарын ажлын ур чадварыг нэмэгдүүлэх, өргөсөн тангарагын биелэлтийг хангаж, хариуцлага тооцох журам тогтоох.



3. Шинэ эдийн засгийн хувьсгал


- 3.1 Улс орны эдийн засаг, иргэдийн амьдралд шууд нөлөөлөхүйц бүтээгдэхүүнийүнийг бодит өртөг, зардалд үндэслэн зохицуулах үр ашигтай механизмыгбүрдүүлж, инфляци, үнийн хэт хөөрөгдлөөс зах зээлийг хамгаалах төрийн бодлогохэрэгжүүлнэ.
- 3.2 Өрхийн үйлдвэрлэлийг татвар, зээлийн бодлогоор дэмжиж, дунд орлоготой бүлгийн эзлэх хувийн жинг нэмэгдүүлнэ.
- 3.3 Монгол улсын эдийн засагт нөлөөлөх салбаруудын үйлдвэрлэлийг төрийн бодлогоор дэмжиж кластирийн системээр хөгжүүлэх
- 3.4 Жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, өрхийн бизнесийг дэмжих зорилгоор зээлийн хэмжээ, хугацаа, нөхцөлийг сайжруулах тал дээр холбогдох байгууллагын саналыг авч олгох журмыг боловсронгуй болгох тал дээр зорилт тавина ажилана.
- 3.5 Үндэсний аюулгүй байдалд учирч буй аюул занал, эдийн засгийн эрсдлийг сааруулах зорилгоор стратегийн барааны импортын эх үүсвэрийг олшруулан төрөлжүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлж импорт орлуулах бодлого хэрэгжүүлнэ.
- 3.6 Уул уурхайн лиценз бол хэзээ ч өмчлүүлэх лиценз биш. Лиценз зөвхөн ашигт малтмалыг эдийн засгийн эргэлтэнд зөв оруулах, эх орон ард түмэндээашигтай ашиглуулах, Монгол улсын санхүүгийн чадварыг дээшлүүлэхэд л хэрэглэх зорилготой.
- 3.7 Мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлж хөдөө аж ахуйг бүрдүүлэгч гол хоёр салбарболох мал аж ахуй болон газар тариаланг төрийн бодлогоор дэмжих. Ингэснээр хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангаж, гаднаас хамааралгүй болох боломжийг бүрдүүлнэ.
- 3.8 Гол нэрийн хүнсний барааны бодит үнийг тогтвортой барих төрийн бодлогыг цаг алдалгүй хэрэгжүүлнэ.
- 3.9 Газрын тосны бүтээгдэхүүний олборлолтыг нэмэгдүүлж, газрын тос боловсруулах, шатдаг занар, хүрэн нүүрснээс хий, шингэн түлш үйлдвэрлэн дотоодын хэрэгцээг хангахын тулд ойрын, дундын, урт хугацааны хөтөлбөр боловсруулан.
- 3.10 Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн гарцийг тодорхойлж, эрсдлийн менежментийн хөтөлбөр боловсруулна.
- 3.11 Эдийн засгийн бас нэг хөшүүргийн асуудал Баялгийн зөв менежментийг хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулна.
- 3.12 Хөрөнгө оруулалтын орчныг тодорхой, тогтвортой болгож, хөрөнгө оруулалтад учирч байгаа хүндрэлийг арилгах, өрсөлдөх боломжийг нэмэгдүүлэхэд анхаарна.
- 3.13 Хувиараа хөдөлмөр эрхлэгч, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг бодлогоор дэмжин, ажилгүйдлийг бууруулна
4. Хариуцлагатай шинэ төрийг төлөвшүүлэх хэрэгжүүлэгч НАМ
- 4.1 Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулж, агаар, хөрсний бохирдолыг бууруулна.



- 4.2 Цахилгаан, дулаан, эрчим хүч болон нефть бүтээгдэхүүний үнийг Монгол Улсын бүх нутаг дэвсгэрт нэг түвшинд байлгах бодлого хэрэгжүүлнэ.
- 4.3 Үндэсний спорт, наадгай, өв соёл, язгуур урлагийг хөгжүүлэн хөгжүүлж, биеийн тамир, спорт, соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- 4.4 Дотоодын зах зээлийн тогтвортой байдлыг хангахад гадаад худалдааны бодлогыг чиглүүлж, улмаар дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай үндэсний брэнд бараа, үйлчилгээний нэр төрлийг олшруулна.
- 4.5 Шинэ үйлдвэржилтийн бодлогын хүрээнд үндэсний хэмжээний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх.
- 4.6 Газрыг ашиглах, эзэмших, өмчлөх харилцааг зах зээлийн эдийн засгийн нийтлэг жишигт нийцүүлэн газрын салбар дундын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, байгалийн бүх төрлийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх цогц бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.7 Ард нийтийн санал асуулгын тогтолцоог боловсронгуй болгож нийгмийн бүлгүүдийн санал асуулгын сүлжээг төгөлдөржүүлэн хөгжүүлнэ.
- 4.8 УИХ-аас баталж байгаа хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг хүний эрхэд суурилсан хандлагаар боловсруулах журам мөрдүүлж, хэрэгжүүлэх мэдлэг чадавхийг бүрдүүлнэ.
- 4.9 Хашааны газрыг орон сууцаар солих ажлыг дэмжих хөтөлбөрийг боловсруулна.
- 4.10 Эх орон, ард иргэдээ өрийн хүлээсэнд оруулахгүй байх бүх талын боломжийг дайчлан ажиллана.
- 4.11 Жолоочийн хариуцлагын даатгалыг улам боловсронгуй, иргэдэд чирэгдэл багатайгаар шийдвэрлэдэг болгох тал дээр хууль санаачилна.

5. Үндэсний аюулгүй байдал

- 5.1 Гадаад бодлогынхоо агуулгыг гүнзгийрүүлэх, олон улсын аюулгүй байдлын хамтын ажиллагаанд оролцох идэвх, чармайлтаа нэмэгдүүлэх, шинэ утга агуулгаар баяжуулах, харилцан ашигтай гадаад харилцааг өргөжүүлэх замаар үндэсний болон геополитикийн аюулгүй байдлын олон улсын таатай орчинг бүрдүүлнэ.
- 5.2 Үндэсний нэгдмэл эрх ашгийн үүднээс улс төрийн нам хүчин, төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, тэдний санал санаачлагыг дэмжинэ.
- 5.3 Батлан хамгаалах арга хэмжээг мэргэжлийн өндөр түвшинд хүргэхийг бодлогоор дэмжиж зэвсэглэл техникийн шинэчлэл, бие бүрэлдэхүүнийг мэргэшүүлэх, цэргийн шинжлэх ухаан технологи, боловсролыг хөгжүүлэхэд анхаарч ажиллана.
- 5.4 Зэвсэгт хүчнийг мэргэжлийн үйл ажиллагаа, мэргэжлийн бүрэлдэхүүнд суурилан хөгжүүлнэ.
- 5.5 Зэвсэгт хүчний эх орноо батлан хамгаалахад бэлэн байх үндсэн үүргээ биелүүлж, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох чадавхи боломжийг нэмэгдүүлнэ.



5.6 Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвийг олон улсын стандартад нийцүүлэн тоноглож, үндсэн чиг үүргийн болон энхийг дэмжих ажиллагааны жишиг анги, Зэвсэгт хүчний хангалт, үйлчилгээний баазын тогтолцоог өргөжүүлэх.

5.7 Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, хил хамгаалах байгууллагын мэргэжлийн бие даасан байдлыг улам бэхжүүлнэ.

5.8 Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгож, улсын хилийг шинжлэх ухааны ололтод тулгуурласан бүсчилсэн байдлаар хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.9 Монгол Улсын хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэнэ.

5.10 Тусгаар тогтнол, нэгдмэл эх бодлоготой үзэл баримтлалыг дээдэлж, Монгол Улсын иргэдийн эх оронч үзэл, хариуцлагатай хүмүүжил төлөвшлийн хөтөлбөрийг боловсруулна.

5.11 Цацраг идэвхт бодис, цөмийн эрчим хүч ашиглахтай холбоотой асуудлаарх төрийн бодлогыг шинэчилж тогтоон. Байгаль орчин, иргэдэд аюултай бол энэ төрлийн бизнес, үйл ажиллагаанаас татгалзах бодлого баримтална.

5.12 Цөмийн хог хаягдлыг Монгол Улсад булшлахгүй, байрлуулахгүй байх бодлогыг тууштай баримтална.

5.13 Усны хэрэглээг зохистой болгох, нуур цөөрмийг сэргээж, шинээр үүсгэх, усан сангууд байгуулах бодлого, үйл ажиллагааг дэмжинэ.


5.14 Ард иргэдийг нутаг ус, жалга дов, нам, эвсэл, хөдөө, хот, хөрөнгө чинээгээр нь талцуулан хувааж, сонгуульд ялсан нам нь ялагдсан намынхаа гишүүдийг хоморголон халж олныг хамарсан гомдол, бухимдлыг бий болгодог нь иргэдийг талцал хуваагдалд оруулж монголын нийгмийг бутаргасан, задарсан, бухимдал бий болгоод байгаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс хариуцлагатай төртэй нэгдмэл бодлоготой эх оронч үзэл төлөвшүүлэх эв нэгдэл, шударга ёс шаардлагатайг харуулж байна.

Иймд хариуцлагатай төрийн тогтолцоог бий болгох хөтөлбөр боловсруулах.

Монгол Улсын Их Хурлын сонгууль нь нийт монголчуудын ялалт, амжилт, хөгжил дэвшлийн төлөөх өрсөлдөөн гэдэгт бид итгэдэг. Бусдыг муулахгүй, хийх ажил, хөтөлбөрөө тайлбарлаж иргэдийнхээ дэмжлэгийг авахыг хичээж ажиллана. Нэгдмэл бодлоготой эх оронч үзэлтэй хариуцлагатай төрийг төлөвшүүлэх эв нэгдэл, шударга ёсыг эрхэмлэнэ.

Төр нийгмээ хариуцлагатай, байгаль дэлхийгээ эрүүл, цэвэр байлгаж, төр засаг, нутаг орон, өрх гэрийнхээ жинхэнэ эзэд болж явах нь монголчууд бидний зарчим билээ.

Хэрэв бид Улсын Их Хуралд тодорхой суудал авбал Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгосон бүрэн эрх, үүргийг шударгаар хэрэгжүүлж, ард түмнийхээ нийтлэг эрх ашгийг ямагт дээдэлж, Монгол Улс Нэгдмэл бодлоготой эх оронч үзэлтэй, Хариуцлагатай төр засагтай гэдгийг батлан харуулах болно.



Монгол Улс Их засаг хуулиа дэлхий дахинаа анх тунхаглаж, шударга ёсыг тогтоож байсан агуу түүхтэй гүрэн, Монголчууд бид шударга, Хариуцлагатай байхдаа зоригтой, эвтэй байхдаа хүчтэй, Нэгдмэл бодлоготой эх оронч үзэлтэй, уул усаа шүтэж амьдардаг агуу ард түмэн билээ.

Энэ сонгууль бол хэн нэгэн хүнийг албан тушаал, эрх мэдэлд хүргэх төдий бус харин Монгол Улсын хөгжил дэвшил, газар нутгийн бүрэн бүтэн байдал, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолоо хамгаалах, нэгдмэл бодлоготой эх оронч үзэлтэй хойч үеийнхээ баталгаат амьдралын төлөө сонголтоо хийх түүхэн сонгууль болно.

Түмэн олны минь заяа түшиж

Төр улс минь амар амгалан оршиг

Ард түмний минь буян заяа, ажил үйлс, хийморь нь өөдөө байг.

Эх орон минь Мөнхөд оршиг ээ...

ЭРХ ЧӨЛӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ НАМ



Харилцах утас:

99113439, 8811-7157, 99113869

8489033 СБТ11426

2020 оны 3 сарын 19